БАТЛАВ
УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ З.БАТБАЯР

ЗАВХАН АЙМАГТ ХӨВ ЦӨӨРӨМ ШИНЭЭР БАЙГУУЛАХ
АЖЛЫН ДААЛГАВАР (ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ)

2025.03.31 Дугаар 04 Улаанбаатар хот

1.	Үндэслэл	"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.3.10 дахь заалт; Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр. Монгол улсын 2025 оны Төвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XIII.1.1
2.	Байршил	1. Завхан аймгийн Цагаанчулуут сум, Дэлгэр баг, Их булгийн ам, 47°07'46" N 96°53'37" E 2. Завхан аймгийн Ургамал сум, Нуур зөөхий баг, Улааг дэнж 48°42'34.13'' N 94°28'0.06'' E 3. Завхан аймгийн Сантмаргац сум, Баяндавст баг, Шивээт эрээний магнай 48°46'39.05'' N 95°23'10.39'' E 4. Завхан аймгийн Завханмандал сум, Төлөгний баруун хөндий 48°14'18.25'' N 95°04'17.76'' E 5. Завхан аймгийн Дөрвөлжин сум, Онц баг, Бага нуур 47°53'25.50'' N 94°09'39.60'' E
3.	Хүчин чадал, зориулалт	1. Батлагдсан зураг төсөвт заасан хүчин чадалтай байх: - Боомтын хярын урт – 20.0 м - ээс багагүй - Хөвийн эзлэхүүн – 20,000.0 м^3 - ээс багагүй - Усны хамгийн их гүн – 1.5 м - ээс багагүй 2. Цөөрмийн тэжээгдэл: - Гол, үер, хур тунадасны ус; 3. Зориулалт: - Бэлчээрийн усан хангамж (ан амьтан, мал); - Газар тариалангийн усалгаа; - Ногоон байгууламж болон модны усалгаа;
4.	Усны барилга, байгууламж барих үе шат, хугацаа, тайлан	- Тухайн газарт инженер, геологи, ус зүйн судалгаа хийх; - Нэг маягийн зургийн дагуу холболтын зураг хийж захиалагчаар батлуулах; - Усны барилга, байгууламж барих ажил 1 үе шаттай;
5.	Барилгын үндсэн бүтээц, хийцийн шийдэл	- Шороон боомт; - Ус хаях суваг бетон хийцтэй байх; - Хөв цөөрмийн инженер геодези, ус зүйн тооцоо хийх; - Ус гаргуур төсөллөх; - Боомтын хярын өргөн хэсэгт нэмэлт арга хэмжээ төлөвлөх, (явган хүний зам, гүүрэн гарц, хайс хашлага хийх);
6.	Санхүүжилт	Улсын төсөв, Нийт: 476,500,000 төгрөг (дөрвөн зуун далан зургаан сая таван зуун мянга)
7.	Тайлан	- Гэрээнд заасан хугацаагаар (2025 оны 11 сарын 01-д багтааж хүлээлгэн өгөх); - Тайланг бичмэл болон цахим, видео хэлбэрээр ирүүлэх; - Холбогдох баримт бичиг, судалгааны материалыг өнгөтөөр *.pdf форматаар 300 dpi нягтралтай скайнердаж cd-нд хавсаргах;
8.		<u>Хууль тогтоомжууд:</u> - Монгол Улсын Үндсэн хууль

	Ажил гүйцэтгэхэд дагаж мөрдөх барилгын норм, дүрэм	- Байгаль орчныг хамгаалах тухай хууль - Усны тухай хууль - Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль - Газрын тухай хууль - Барилгын тухай хууль <u>Норм нормативууд:</u> - Барилгын геодезийн ажил /БНбД 11-08-06/ - Барилга захиалагчийн дүрэм - Барилгын бүтээц ба бууриийн найдваршил. - Ерөнхий шаардлага /БНбД 20-01-11/ - Ачаалал ба үйлчлэл /БНбД 20-04-17/ - Газар хөдлөлтийн бус нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм /БНбД 22-01-01*/ - БНбД 11-07-04 Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг дүрэм - БНбД 33-01-03 Усны барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах үндсэн журам - БНбД 33-03-05 Голын гидротехникийн барилга байгууламж - БНбД 33-04-09 Усны барилга байгууламжийн суурь - БНбД 33-05-09 Усны барилгын ачаалал ба үйлчлэл - БНбД 33-06-09 Усны барилга байгууламжийн бетон ба төмөр бетон бутээц - БНбД 33-08-09 Бетон ба төмөр бетон боомт - БНбД 81-33-10 Усны барилгын төсвийн суурь норм - БД 81-105-11 Усны барилга байгууламжийн инженер хайгуул судалгааны ажлын жишиг норм - БД 81-106-11 Усны барилгын зураг төслийн ажлын жишиг үнэ - Барилгын төсөв зохиох дүрэм /БНбД 81-95-12/ - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм; Бусад холбогдох норм, дүрэм, стандартууд
9.	Гүйцэтгэгч байгууллагад тавигдах шаардлага	БОУАӨЯ-аас олгодог тусгай зөвшөөрөл: - Усны барилга байгууламж барих, сэргээн засварлах, шинэчлэх, эсвэл ХББОСЯ-аас олгодог тусгай зөвшөөрөл: - Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэл хийх (БА-2.2). - ЗТ 3.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл хийх тусгай зөвшөөрөл
10.	Онцгой нөхцөл	- Газар хөдлөлтөөс үзүүлэх ачаалал, эрсдэлийг тооцсон байх; - Хүн, мал, зэрлэг амьтан осолдохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх; - Усан сангийн орчимд гоц халдварт өвчинтэй сэг, зэм булшилсан эсэхийг сайтар шалгах;

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УСНЫ ГАЗАР